



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Улаанбурхан өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>1.1, 27<sup>1</sup>1.4 дэх заалт, Улсын онцгой комиссын 2025 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 15 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам"-д тус тус заасны дагуу эрүүл мэндийн салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг хязгаарлах хариу арга хэмжээг эрчимжүүлэх, шаардлагатай хүний нөөцийг дайчлан ажиллуулах, үндэсний товллын болон нөхөн дархлаажуулалтын хамрагдалт, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэнд даалгасугай.

2. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд улаанбурхан өвчний үндэсний товллын болон нөхөн дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх, тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг хязгаарлах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд бүх талаар дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллахыг Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад тандалт, хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж, дархлаажуулалт, лабораторийн чиглэлээр цахим сургалтыг зохион байгуулж зөвлөмж, мэдээлэл өгөх, эрсдэлт бүлгийн хүн ам ялангуяа бага насны хүүхдүүд, өндөр настнууд дунд тандалтыг эрчимжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, гэрийн эргэлт, хяналтыг идэвхжүүлэх, улаанбурхан өвчний дэгдэлтийн үед авах хариу арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, вакцин, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, нөхөн дархлаажуулалтыг "Хаалганаас хаалганд" зарчмыг баримтлан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Улаанбурхан өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын эсрэг дархлаажуулалтад олон нийтийг идэвхитэй хамруулах чиглэлээр мэргэжлийн



байгууллагуудтай хамтран зөвлөмж, уриалга, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг тогтмол түгээх, олон нийтэд буруу ташаа мэдээлэл тархахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Н.Баасандамба, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал, Улсын онцгой комиссын гишүүн Г.Гэрэл, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг нэн даруй шийдвэрлэхийг Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

6. Үндэсний товлалт дархлаажуулалт, вакцины талаар олон нийтэд зориудаар хуурамч, мэдээ, мэдээлэл түгээж хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж буй этгээдүүдийг олж тогтоох, үйл ажиллагааг нь таслан зогсоох, холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцохыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Батшугар, Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал П.Одонбаатар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Т.Сүхболд нарт үүрэг болгосугай.

7. Заавал хийх үндэсний товлолын дагуу дархлаажуулалтад хамрагдах 0-15 настай хүүхдийн одоогийн оршин суугаа хаягийг тогтооход Халдварт өвчин судлалын үндэсний төв болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт дэмжлэг үзүүлэхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваанямд үүрэг болгосугай.

8. Хичээлийн шинэ жил эхлэхэд улаанбурхан өвчний халдварын тархалт нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс авч хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, багш, сурагчдыг халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эсэхийг нотлох баримтыг хянах, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан дархлаажуулалтыг хамтран зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн, Боловсролын сайд, Улсын онцгой комиссын гишүүн П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Х.Батжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

9. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН